

Өдрийн цайны хэсэг:

Нийлүүлэлтийн шокод хариу үзүүлэх төсвийн бодлого

Чиглүүлэгч:

- **Очирхүү Эрдэмбилэг** - УИХ-ын даргын Эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх

Илтгэгч:

- **Митали Дас** - Олон улсын валютын сан, Төсвийн бодлогын хэлтсийн зөвлөх

Энэ хуралдаанд ОУВС-ийн Төсвийн бодлогын хэлтсийн зөвлөх Митали Дас илтгэл танилцуулж, түүнтэй УИХ-ын даргын Эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх О.Эрдэмбилэгтэй нийлүүлэлтийн шок (нийлүүлэлтийн гэнэтийн тасалдал, хомсдол)-д хэрхэн үр дүнтэй төсвийн бодлогоор хариу үзүүлэх талаар ярилцсан юм. Тэд энэ үеэр хөгжиж буй зах зээлтэй орнуудын хувьд эдийн засгийн сорилтод хэрхэн оновчтой хариу өгөх талаар мөн ярилцсан билээ. Ялангуяа төсвийн бодлогын оновчтой байдал нь эдийн засагт тулгарч буй шинэ сорилтуудыг хүндрэл багатай даван туулахад чухал нөлөө үзүүлнэ. Хэлэлцүүлгийн үеэр дараах асуудлуудыг онцлов. Үүнд:

Төсвийн бодлогын стратегийн хүрээнд:

- Эдийн засгийн шокын үед зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь чухал,
- Тогтворгүй нөхцөл байдалд хурдан дасан зохицох уян хатан төсвийн хүрээ шаардлага,
- Төсвийн сахилга батыг хадгалахтай зэрэгцэн нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ бий

Эдийн засагт тулгараад буй нийлүүлэлтийн шокийг танихын тулд:

- Төрөл бүрийн нийлүүлэлтийн шокын (цар тахал, геополитикийн эрсдэл, нөөцийн хомсдол гэх мэт) шинжилгээ хийх,
- Нийлүүлэлтийн шок нь уламжлалт эрэлтийн шокоос юугаараа өөр болохыг ойлгох,
- Эдийн засгийн системд бүтцийн эмзэг байдал багаа эсэхийг тодруулах.

Хөгжиж буй зах зээлд тулгарч буй сорилт:

- Үр дүнтэй бодлого хэрэгжүүлэхэд төсвийн орон зай хомс байна,
- Төрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн сэргэлтэд учирдаг хязгаарлалтууд,
- Баялгийн сангийн бүтэц, зориулалтыг сайжруулах хэрэгтэй гэж онцлов.

Бодлогын зөвлөмж:

- Ил тод, хариуцлагатай төсвийн дүрэм боловсруулах,
- Автомат тогтворжуулагч механизмууд (жишээ нь ажилгүйдлийн тэтгэмж) бий болгох,
- Баялгийн сангийн үйл ажиллагааг илүү уян хатан болгох,
- Хямралын үед чухал хөрөнгө оруулалтуудыг хамгаалах,

Нийгмийн хамгааллын бодлогыг илүү зорилтот бүлэг рүү шилжүүлэх.

Ирээдүйд эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхийн тулд:

- Илүү уян хатан эдийн засгийн бодлогын хүрээг бий болгох,
 - Шокиг шингээх чадварыг сайжруулах
 - Улс орнууд эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх хэрэгтэй гэж зөвлөв.
-

МИТАЛИ ДАС-ын онцлох эшлэл:

“КОВИД-19 цар тахал тохиолдсоноор **бүтцийн томоохон асуудлуудыг** ил болгосон... улмаар гарцын зөрүү нь түүхэнд байгаагүй их байв.”

Судалгааны үр дүнгээс харахад цар тахлын уналтын дараа хөгжингүй орнууд эдийн засгийн гарцын алдагдлаа нөхсөн бол хөгжиж буй нэлээдгүй улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийн чиг хандлага нь өөрчлөгдөж, гарцын алдагдал нь хэвээр үлджээ. Үүнийг “мөчлөг нь өөрөө тренд болсон” буюу эдийн засгийн шок нь түр зуурын хэлбэлзэл бус, суурь чиг хандлагыг өөрчилсөн хэмээн дүгнэжээ.

Гол шалтгаан нь нийлүүлэлтийн болон эрэлтийн хос шок, бодлогын хариу арга хэмжээний онцлог, эдийн засгийн салбарын ялгаатай байдалтай холбоотой юм. Цаашид хөгжиж буй орнууд эдийн засгийн шокиг давах чадвараа нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, ил тод тогтолцоо бүрдүүлэх, нийгмийн халамжийн зорилтот дэмжлэгийг үр дүнтэй хэрэгжүүлэх, чанартай, өгөөжтэй хөрөнгө оруулалтыг татах шаардлагатай.